

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН
/2022.05.23 - 2022.05.27/

2022.05.27

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагааны гүйцэтгэл
Барилга хот байгуулалтын хэлтэс		
1	Барилгын ажлын хүрээнд	<ul style="list-style-type: none"> ✓ Төвийн бүсийн барилга экспо-2022-г “Дархан-50” цогцолбор дээр 2022.05.28-29-ны өдрүүдэд 2 өдөр зохион байгуулахаар болсон. Энэхүү Экспод барилга бүтээн байгуулалт, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, амины сууцны шинэлэг шийдлүүдийг оролцуулсан 40 аж ахуйн нэгж байгууллагуудыг оролцуулхаар бэлтгэж ажлыг хангуулж байна.
2	Инженерийн дэд бүтцийн хүрээнд	
4	Барилгын материалын хүрээнд	<ul style="list-style-type: none"> ✓ 2022.05 сараас 6 сар хүртэл хугацаанд Улсын үзлэг тооллогын дэд ажлын хэсэгт ажиллав. Дэд ажлын хэсэг 30-аад байгууллагын <ul style="list-style-type: none"> -газар, QR коджуулалт, мөн Санхүүгийн тайланд зөв үнэлсэн байдал, -барилга байгууламж, хувийн хэрэг бүртгэл хөтлөлт, баяжуулалт, -тээврийн хэрэгсэл, торгууль татвар төлбөр төлсөн байдал зэргийг шалган түүнийг залруулах тухай зөвлөн туслаж ажиллаа.
Газрын удирдлагын хэлтэс		
1	Газрын татвар төлбөр үнэлгээ	<ul style="list-style-type: none"> ✓ 2022 онд аймгийн хэмжээнд 36 нэгж талбарт газрын дуудлага худалдаа зохион байгуулах, Дархан сумын хэмжээнд байгаа 1300 гаруй гаражийн судалгааг гаргаж багийн Засаг дарга нарт хүргүүлсэн бөгөөд ГАРАЖуудын хаалгыг нэг ижил СААРАЛ өнгөөр будуулах, хаалганы гадна хүрээг цагаанаар будуулах, эмульсдэх нэгдсэн хаягжуулалтын ажлыг эхлүүлсэн байна. Энэ ажлын хүрээнд 5-р сард 86 гаражид хаяг олгож, будуулсан байна. Мөн 9, 12-р багийн нутаг дэвсгэрт байрлах гаражуудын хувийн хэргийг нэг бүрчлэн архиваас татаж танилцан, шинэчилсэн бүртгэлд орсон эсэхийг шалгаж шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: <ul style="list-style-type: none"> ✓ 12-р багт 179 гаражийн мэдээлэл манай байгууллагын архивын мэдээллийн санд бүртгэлтэй байна. Үүнээс 5 иргэнд хугацаа сунгах тухай утсаар мэдэгдэж, 13 гэрээг нөхөн бүрдүүлж мэдээллийн санд оруулсан, 9 гэрээний кадастрын зураг байхгүй, байршил тодорхойгүй, утасны дугааргүй тул шинэчлэх боломжгүй байна. ✓ 9-р багт 349 гаражийн мэдээлэл манай байгууллагын архивын мэдээллийн санд бүртгэлтэй байна. Үүнээс 4 иргэнд хугацаа сунгах тухай утсаар мэдэгдэж, 4 гэрээг нөхөн бүрдүүлж мэдээллийн санд оруулсан, 6 гэрээний кадастрын зураг байхгүй, байршил тодорхойгүй, утасны дугааргүй тул шинэчлэх боломжгүй байна. ✓ Газар өмчлөлийн 2070 нэгж талбарын хөрөнгийн бүртгэлийг нэг бүрчлэн аймгийн Татварын удирдлагын нэгдсэн системд илгээж, газрын татварын нэхэмжлэлийг үүсгэсэн. ✓ Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх 2022.05.20-ний өдрийн хурлаар 43 иргэний гаражийн асуудлыг танилцуулж, захирамжийн төсөлд илгээлээ. ✓ Аймгийн хэмжээнд 2022.05.24-ний өдрийн байдлаар 231 барьцааны гэрээ бүртгэж, цахимаар төлбөрийн даалгавар үүсгэж төлүүлсэн байна. Үүнд: Дархан 94, Орхон 21, Хонгор 115, Шарын гол 1 барьцаа бүртгэсэн байна. ✓ Аймгийн хэмжээнд 8315 хүчинтэй гэрээнд ногдол үүсгэснээс 8241 гэрээнд 1.5 тэрбум төгрөгийн нэхэмжлэл үүсгэж Татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн байна.
2	Газрын төлөв байдлын хянан баталгаа, газрын мониторингийн хүрээнд	<ul style="list-style-type: none"> ✓ Захиалгат хянан баталгааны мэдэгдэх хуудас 8 нэгж талбарт үүсгэж, 3 тайлан баталгаажуулж 3 тайланг хянаж буцаав. ✓ Байгууллагын цахим төвд 2022.05.23-ний өдөр ажиллаж иргэдэд зөвлөгөө өгч, цахим хүсэлтийг илгээж ажиллав. (Газар өмчлөлийн лавлагаа 35 иргэн, 18 хүүхдэд гаргаж өгөв) Дүйцүүлэн хамгаалах газрын судалгааг Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Д.Баянмөнхтэй хамтран хийж гүйцэтгэв.
3	Геодези, зураг зүйн,	<ul style="list-style-type: none"> ✓ Хаягийн зургийн дагуу 5 иргэн, 2 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар

	кадастрын хүрээнд	<p>олгосон.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж, хуваалт / хэмжилт хийлгэсэн 4 иргэн, 0 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан. ✓ Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлсэн 3 иргэний материалыг хянаж өмчлөх эрхийг шилжүүлсэн. ✓ Дархан Ус суваг ХК-аас авто машины зогсоол хийхээр хүсэлт ирүүлсэний дагуу тухайн газарт хэмжилт хийсэн.
Захиргаа аж ахуйн чиглэл		
1	Хүний нөөц, хууль эрх зүй, дотоод ажлын хүрээнд	<p>Сургалт:</p> <ul style="list-style-type: none"> ✓ ТАЗөвлөлөөс зохион байгуулсан 7:4:10, Монгол улсын Оюун ухааны академийн захирал Х.Хатанбаатар “Бүтээлчээр хурдан уншихуй” сэдэвт цахим сургалтад байгууллагын 2 албан хаагч хамрагдсан.
2	Мэдээллийн технологи, нярав	<p>Мэдээлэл: 70376471 нээлттэй утсаар 6 иргэний асуултанд хариулт өгөв. Байгууллагын Facebook хуудсанд ирсэн 1 иргэний асуултанд хариулт өгөв. 2022-05-24-нд цахим төв дээр ажиллав.</p> <p>Мэдээлэл технологийн чиглэлээр: Байгууллагын цахим хуудас болон Фэйсбүүк хуудсан дээр Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны талаарх мэдээлэл байрлуулав. Нөхөн бүрдүүлэлтийн ажил хийгдэж буйтай холбогдуулан Дархан сумын 9-р багийн 361 ширхэг гаражуудын нэгж талбарын хувийн хэргийг архиваас татаж аван шинэчилсэн бүртгэлд хамрагдсан эсэхийг шалгаж хугацаа нь дууссан, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй нэгж талбарын хувийн хэргүүдийг хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэж өгөв. Хонгор сумын газрын даамал Гантуяагийн компьютерыг форматлаж, програм суулгав. Кадастрын мэргэжилтний компьютерт хэрэглээний програм суулгаж өгөв.</p> <p>Нярав: 0 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалж мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 1 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 26 ширхэгийг хүлээж авч бүртгэв. Шаардах хуудсаар 2 төрлийн 1.5 ширхэг бараа материал олгов.</p>

Тайлан боловсруулсан:
Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Хянасан:
Газрын удирдлагын хэлтсийн дарга

Б.Золбаясах
Г.Нямдорж